



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/243

Арвайхээр

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Дүрэм, журам батлах тухай” А/243 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ын 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, Насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, үүссэн зөрчил дутагдлыг арилгах үүрэг чиглэл бүхий аймгийн Боловсролын салбарын “Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Дүрэм, журам батлах тухай” А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах, зөрчил гаргасан албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцох, багш, ажилтны ёс зүйн зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газар (Н.Чимэддорж-Ойдов)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0525

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 12-ны өдрийн
11043 дугаар захирамжийн
хавсралт

АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН “ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх
ухааны газрын Бодлого төлөвлөлт хяналт-шинжилгээ,
үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын
байцаагч

Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 дүгээр
сургуулийн Захирал

Арвайхээр сумын 11 дүгээр цэцэрлэгийн Эрхлэгч

Багшийн төлөөлөл (Ч.Оюунцэцэг Арвайхээр сумын
ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн багш)

Эцэг эхийн төлөөлөл (Л.Мэнд-Амар)

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх
ухааны газрын дарга

-оОо-